

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ ҮР ДҮНГИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 17

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ 2025 оны 04 сарын 17-ны өдрийн 14.00 цагаас танхимаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулснаар 14.00 цагт 40077 хувьцаа эзэмшдэг гишүүд оролцсоноор 98.5 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцов.

- Хувьцаа эзэмшигч Ш.Үнэнбат гадаад явсан, С.Тунгалаг, ажилтай ирцэд оруулахаар саналаа ирүүлсэн.
- Хувьцаа эзэмшигч Г.Ганболд ажилтай тул ирж амжихгүйгээ мэдэгдсэн.
- Хувьцаа эзэмшигч Г.Буд, Г.Болд нар хүнд өвчтэй тул оролцоогүй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-өөс гаргасан тогтоолын төсөл, хурлын дэгийг танилцуулав. Хурлаар хэлэлцэх асуудал 100 хувийн санал нэгдэж батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчээр Л.Шагдаррагчаа, Б.Бурмаа, Б.Батцагаан нарыг сонгов. Мөн тооллогын комиссыг Б.Энхболд, Г.Мягмар, Б.Гэрэлт-Од нарын бүрэлдэхүүнтэй сонгож томилов.

Хуралд дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн /ТУЗ/ тайлан, дүгнэлт -“Барилга” ХК-ийн ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа
2. Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан, гэрээт аудитын тайлан, дүгнэлт -Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны чиглэл, 2024 оны үр дүнгийн урамшуулал болон ногдол ашиг хуваарилах тухай-“Барилга” ХК-ийн дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат
4. Компанийн хувьцааны эзэмшил, Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай мэдээлэл -“Барилга” ХК-ийн дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат
5. Компанийн ТУЗ-ийг сонгох, гүйцэтгэх захирлыг томилох тухай -“Барилга” ХК-ийн ерөнхийлөгч, ТУЗ-ий дарга Л.Шагдаррагчаа

“Барилга” ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ийн 2024 оны тайланг уншиж танилцуулав. ТУЗ-ийн даргын 2024 оны тайланг хавсаргав

Үүний дараа Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх 2024 оны санхүүгийн тайлан болон санхүүгийн зохицуулах хорооны тусгай эрх бүхий “ Дундманхайдай ” ХХК-ийн аудитын дүгнэлтийг болон аудитороос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг уншиж танилцуулав. Мөн өгөгдсөн зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг танилцуулав. 2024 санхүүгийн тайланг болон аудитын дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ ҮР ДҮНГИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Барилга” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат өнгөрсөн 2024 оны байгууллагын тайлан, үйл ажиллагааны үр дүн болон ирэх оны үйл ажиллагааны чиглэлийн талаархи тайлангаа уншиж танилцуулав. Нэмэлтээр үр дүнгийн тухай танилцуулга хийв. Гүйцэтгэх захирлын 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хавсаргасан болно.

Л.Шагдаррагчаа: Үндсэн 3 тайлантай холбогдолтой санал, асуулт байна уу?

Б.Батцагаан: Санхүүгийн тайлан дээр 2024 онд гүйцэтгэл бага мөртлөө НД-ын шимтгэл өссөн байна. Үүнийг тодруулж өгөөч.

Э.Батсүх: НД-ын Ерөнхий газрын тушаалаар цалингаас суутгах шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдсэн мөн цалингийн шатлал, цалингийн доод хэмжээ нэмэгдсэн зэргээс болж өссөн юм.

Г.Мягмар: 2024 оны ЭМД, НД-ын шимтгэлээс 2025 оны ЭМД, НД-ын шимтгэл зөрүүтэй, бага байна.

Э.Батсүх: 2024 онд орлого, гүйцэтгэл өндөр байсан. 2025 оны төлөвлөгөөнд багаар тавигдсан учир шимтгэл буурсан харагдаж байна.

Л.Шагдаррагчаа: Улсад өглөг байгаа юу?

Э.Батсүх: Бага зэрэг өр байгаа, 2-3 сарын НДШ-ийн өр байна.

Л.Шагдаррагчаа: ОТ-с орж ирж байгаа санхүүжилттай холбоотой байна уу?

Э.Батсүх: Тиймээ, санхүүжилт 1-2 сар хоцорч орж ирж байгаа учир өр үүссэн.

Л.Шагдаррагчаа: Өөр асуух асуулт байхгүй бол санал сонсоё.

Г.Мягмар: Тайлангууд, үзүүлэлт баланс сайн байна. Компани өөрөө урт удаан хугацаанд тогтох үндэс бол мэргэжилтэй ажилтан юм. Тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах, итгэл үнэмшлийг төрүүлэх арга бол хувьцаа эзэмшүүлэх явдал юм. ОУ-ын жишиг байдаг. Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр байдаг. Судлаж үзээрэй.

Э.Энхболд: Хүндрэлтэй нөхцөлд сайн ажилласан байна. Олон хүнийг ажлын байраар хангаж ажиллаж байгаа нь сайшаалтай. Өөрийн олон ажилтнуудыг мэргэшүүлэхийн тулд сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил ахиулах, дэргэдээ сургалтын баазтай болж ажиллах нь зүйтэй юм.

Л.Шагдаррагчаа: Санал хэлсэн та бүхэндээ баярлалаа. Санал хэлэлцэж дууссан тул одоо Тооллогын комиссыг ажилд оруулав. /Тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав/ Энэ удаагийн хурлаар кумулятив аргаар тооллого явуулав.

Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Тогтоол №3-г 100 хувь саналаар батлав.

Л.Шагдаррагчаа: 4,5, 6 тогтоолуудын төсөл уншиж танилцуулав.

**БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ ҮР ДҮНГИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Тогтоол тус бүрийг 100 %-ийн санал нэгтэй дэмжиж батлав.

Мөн Тогтоол №7 “2025 оны үндсэн үзүүлэлтийг батлах тухай”, Тогтоол №8 “Ногдол ашгийн хуваарилалтын тухай”, Тогтоол №9 “Компанийн удирдлагыг сонгох тухай”, Тогтоол №10 “Компанид хувьцаа худалдан авах тухай” 100%-ын саналтай дэмжиж батлав.

Өөр санал гарсангүй, хурал 16.00 цагт дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг албажуулав. Хурлын тогтоол, шийдвэр хэлэлцсэн асуудлуудыг нэгтгэж Санхүү зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг даалгав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.АРИУНТУЯА

Б.АРИУНТУЯА